



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/665

Хэрлэн сум

Г
Үс зүйн зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16 дахь заалт, Боловсрол шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалын 2 дахь заалт, уг тушаалаар батлагдсан “Үс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам”-ын 2.1.3, 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дурмийн 6.4, 6.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах, тайлагнах үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|--------------------------|--|
| Дарга: | Аймгийн Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн
дарга: | Боловсрол шинжлэх ухааны газрын дарга |
| Гишүүд: | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын Эх хэлний судлагдахуун хариуцсан мэргэжилтэн
“Тэмүүжин” цогцолбор сургуулийн захирал
Хэрлэн 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
Хэрлэн 1 дүгээр сургуулийн багш
Хэрлэн 4 дүгээр сургуулийн Эцэг эхийн зөвлөл |

2.

Хүний эрхийн комиссын ахлах мэргэжилтэн

2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавихдаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн холбогдох хууль, тогтоомж болон тус дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулан, ёс зүйн зөвлөлөөс ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулах сургалт, үйл ажиллагааны зардлыг ашигтай зарцуулахыг Зөвлөлийн дарга (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/298 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

